



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/363

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын дархан аварга Х.Баянмөнхийн бүтээл үндэсний бөхийг судлан суралцахад зориулагдсан “Монгол бөхийн ов мэх” ном худалдан авах зардалд 3 960 000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.


2. Ном худалдан авахад зарцуулах 3 960 000 төгрөг /гурван сая есөн зуун жаран мянган/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 5.27-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/ нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны
07 дугаар сарын 07-ны өдрийн
А/363 дугаар захирамжийн хавсралт



“МОНГОЛ БӨХИЙН ОВ МЭХ” НОМЫН ЗАРДАЛ
/ТӨГРӨГӨӨР/

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ /мянган төгрөг/
1.	“Монгол бөхийн ов мэх” НОМ	багц	11	360 000	3 960.0
Нийт дүн					3 960.0

-oOo-